

“АСБИ” ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 04 сарын 30-ны өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

Хурал: 2023 оны 04-р сарын 30-ны өдрийн 10.00 цагт Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс, Ажилчны гудамж 51/1 тоот “Асби” ХК-ийн хурлын танхимд боллоо.

Хурлын ирц: Хуралд нийт 59,670 ширхэг хувьцаа эзэмшиж буй 4 хувьцаа эзэмшигч оролцсоноос танхимд 4 хувьцаа эзэмшигч ирсэн байна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц болон хурал хүчин төгөлдөр болсон тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 сарын 21-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах тухай 02 тоот тогтоолоор томилогдсон Тооллогын комиссын 2023 оны 04 сарын 30-ны өдрийн 01 дугаартай тогтоолыг Тооллогын комиссын дарга М.Сугармаа уншиж танилцууллаа.

Тогтоолд: “Асби” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаанд багтсан нийт 63,456 ширхэг хувьцаа эзэмшдэг 57 хувьцаа эзэмшигчээс 4 хувьцаа эзэмшигч ирж хуралд оролцсон нь 59,670 ширхэг хувьцаа буюу нийт саналын эрхтэй хувьцааны 94.03% болж Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах ирц бүрдэж, хурал хүчин төгөлдөр болсныг зөвшөөрч баталсугай.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал нээж, хурлын дарга Д.Лхагвасүрэн үг хэлэв.

-Сайн байцгаана уу. Цаг заваа зориулан хуралдаа ирсэн та нарт баярлалаа. Хувьцаа эзэмшигчдээс гадна Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Ц.Хадаа хүрэлцэн ирсэн байна. Ингээд хэлэлцэх асуудлуудаа хэлэлцээд шийдвэрүүдээ гаргаад явъя.

Хэлэлцэх асуудал 1,3 : Компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн хараат бус аудиторын дүгнэлт, ТУЗ-ын дүгнэлт, ТУЗ-ын зардлын төсөв батлах тухай.

Л.Сүмбанд: Ойрын хэдэн жил ковидын нөхцөл байдлаас шалтгаалаад компанийн үндсэн үйл ажиллагаа ерөнхийдөө зогсонги байдалд орж, түрээсийн орлогоор санхүүжиж ажиллаж байсан. Энэ оноос үйл ажиллагаагаа идэвхижүүлж, үр бүтээлтэй, ахиц дэвшилтэй ажиллах төлөвлөгөөтэй байна. Хөндлөнгийн аудитын дүгнэлт дээр асуулт алга. Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ын зардлын төсвийг дэмжиж байна.

Д.Лхагвасүрэн: Бусад хувьцаа эзэмшигчээс асуулт, санал байхгүй юу? Байхгүй бол дараагийн асуудалдаа орё.

Хэлэлцэх асуудал 2: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай.

Энэ жил ТУЗ-ын гишүүдийг улируулан сонгохоор санал хурааж байгаа. Саналаа кумулятив санал хураалтаар явуулъя.

Асуулт хариулт гараагүй.

Хурлын дарга Д.Лхагвасүрэн: Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт хариулт байхгүй тул санал хураалтаа явуулж, хурлын шийдвэрээ гаргая

Тооллогын комиссын дарга М.Сугармаа: Санал хураалтын хугацаа дууссан байна. Санал хураалтын дүнг танилцуулъя. 2023 оны 04 сарын 30-ны өдрийн Тооллогын комиссын 02 тоот тогтоолыг уншиж танилцууллаа.

Компанийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх заалт 2023 оны 04 сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэрлэсэн нь:

Нэгдүгээр асуудал: “Асби” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол 2023 оны 04 сарын 30-ны өдрийн 01 тоот “Компанийн тухай хуулийн 62-р зүйдийн 62.1.9 дэх заалт, 2023 оны 04 сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Асби” ХК-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.

Хоёрдугаар асуудал 2: “Асби” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол 2023 оны 04 сарын 30-ны өдрийн 02 тоот “Компанийн тухай хуулийн 62-р зүйдийн 62.1.7 дэх заалт, 2023 оны 04 сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Асби” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр

1. Д.Лхагвасүрэн
2. Л.Сүмбанд
3. Ч.Дашцэрэн
4. С.Буман-Эрдэнэ
5. Б.Доржсүрэн
6. С.Бат-Эрдэнэ

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр

1. Э.Буянтогтох
2. Л.Нямдаваа
3. Ц.Хадаа нарыг тус тус сонгосугай.

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, Компанийн дүрэм болон бусад хууль тогтоомжийг баримтлан, компанийн эрх ашгийг дээдлэн ажиллахыг үүрэг болгосугай.

Хэлэлцэх асуудал 3: “Асби” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол 2023 оны 04 сарын 30-ны өдрийн 03 тоот “Компанийн тухай хуулийн 62-р зүйдийн 62.1.13 дэх заалт, 2023 оны 04 сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “АСБИ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагын 2023 оны төсвийг 9,000,000 /есөн сая/ төгрөгөөр тогтоосугай.

2. Төсвийн зардалд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргад даалгасугай.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Намуунтуул

ХУРЛЫН ДАРГА Д.ЛХАГВАСҮРЭН

